



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 03 дугаар сарын 01  
№09 (1257)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

155.	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай	699
156.	Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай	724
157.	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	725
158.	Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	726

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

159.	Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 11	727
------	--	-----------	-----

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

160.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 04	736
161.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 05	748





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээ, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хууль тогтоомж

2.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Банкны тухай хууль<sup>2</sup>, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль<sup>3</sup>, Хөрөнгө оруулалтын тухай хууль<sup>4</sup>, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль<sup>5</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Банкны тухай хуульд заасны дагуу банк байгуулах тусгай зөвшөөрөл авсан банкны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Хөрөнгө оруулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

3.3.Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаатай холбогдох харилцааг Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

3.4.Монгол Улсын Хөгжлийн банктай холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэж төслийг дунд, урт хугацааны тогтвортой хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө хуулийн этгээдийг;

4.1.2.“төсөл” гэж санхүүгийн хөрөнгийн дунд, урт хугацаатай эх үүсвэр шаардлагатай, уг эх үүсвэрийг орлогоороо нөхөх боломжтой эдийн засгийн үйл ажиллагааг;

4.1.3.“харилцагч” гэж хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас санхүүжүүлж байгаа төслийг санаачлагч, хэрэгжүүлэгч хуулийн этгээд болон Монголбанкнаас төслийн оролцогч гэж үзсэн бусад хуулийн этгээдийг.

#### **5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хэлбэр, хувь нийлүүлсэн хөрөнгө**

5.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь хаалттай хувьцаат компани, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байна.

5.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын түвшин, улсын төлбөрийн тэнцлийн үзүүлэлт, төгрөгийн ханшийн өөрчлөлт, банкны төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны онцлог, банкны салбар дахь төслийн санхүүжилтийн хэмжээ, шаардлагатай бусад хүчин зүйлсийг харгалзан Монголбанк тогтооно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагаа**

6.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжих төсөл санхүүжүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

6.1.1.зээл олгох;  
6.1.2.төлбөр тооцоо;  
6.1.3.баталгаа, батлан даалт;  
6.1.4.үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах;  
6.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, арилжих;  
6.1.6.андеррайтер;  
6.1.7.кастодиан;  
6.1.8.санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.

6.2.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Монголбанк, энэ хуулийн 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгоно.

6.3.Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 6.2-т заасан зөвшөөрлийг олгохдоо тухай бүр Монголбанкны саналыг урьдчилан авна.

### **7 дугаар зүйл.Зээл олгох**

7.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчид зээл олгож болно.

7.2.Төсөлд олгох зээлийн хэмжээ, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг банкны системд нөлөө бүхий банкнаас хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээ, бусад хүчин зүйлийг харгалзан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран тогтооно.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан зээлийн хугацаа 2 жилээс доошгүй байна.

7.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны барьцаалсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах бол Ашигт малтмалын тухай хуулийн<sup>6</sup> 7.1-д заасан нөхцөлийг хангасан эрх бүхий этгээдэд зөвхөн дуудлага худалдааны үндсэн дээр шилжүүлнэ.

## **8 дугаар зүйл.Төлбөр тооцоо**

8.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуулийн 6.1.1, 6.1.3, 6.1.4, 6.1.6-д заасан үйл ажиллагаанд шууд хамаардаг харилцагч болон Монголбанк, банкны төлбөр тооцоог гүйцэтгэж болно.

8.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг холбогдох хуульд заасны дагуу зохицуулна.

## **9 дүгээр зүйл.Баталгаа, батлан даалт**

9.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14.1-д заасан хязгаарлалтын хүрээнд дангаар болон бусад этгээдтэй хамтран төсөл санхүүжүүлэхтэй холбогдуулан харилцагчийн хүлээсэн үүрэгт гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргаж болно.

9.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас гаргах баталгаа, батлан даалтад тавих шаардлага, нөхцөлийг Монголбанкнаас баталсан журмаар зохицуулна.

## **10 дугаар зүйл.Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах**

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах зорилгоор мөнгөний зах зээл дээр богино хугацааны үнэт цаас гаргаж болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

<sup>6</sup>Ашигт малтмалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэл хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Энэ хуулийн 14.3-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, бүртгэл, хэмжээ, хэлцэл хийхэд баримтлах журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

### **11 дүгээр зүйл.Гадаад валют худалдах, худалдан авах, арилжих**

11.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь энэ хуулийн 6.1.1, 6.1.6-д заасан үйл ажиллагааны хүрээнд харилцагчийн төлбөр тооцоог гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэхэд үүсэж болох гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор гадаад валют худалдах, худалдан авах, түүнтэй холбоотой валют арилжааны бусад хэлцлийг хийж болно.

11.2.Энэ зүйлийн 11.1-д заасан үйл ажиллагааг Валютын зохицуулалтын тухай хууль<sup>7</sup> болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

### **12 дугаар зүйл.Андеррайтер, кастодиан, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа**

12.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас төсөл санхүүжүүлэхтэй холбоотойгоор энэ хуулийн 6.1.6, 6.1.7, 6.1.8-д заасан үйл ажиллагааг эрхлэх харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

### **13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд хориглох үйл ажиллагаа**

13.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

13.1.1.энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх;

<sup>7</sup>Валютын зохицуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 06 дугаарт нийтлэгдсэн.





13.1.2.мөнгөн хадгаламж, хүү төлөх нөхцөлтэй харилцаа данс нээх, тэдгээртэй адилтгах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх;

13.1.3.хараат болон охин компани үүсгэн байгуулах;

13.1.4.банк, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын хуулийн этгээдийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг худалдан авах.

#### **14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт, шаардлага**

14.1.Аливаа этгээд, түүний холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд олгох хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлтэй адилтган тооцох хөрөнгийн хэмжээ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг гурав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.2.Зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгийн нийт дүн нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг арав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.3.Баталгаа, батлан даалт, эзэмшиж байгаа үнэт цаасны нийт дүнгийн нийлбэр нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийг тав дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.4.Энэ зүйлд зааснаас бусад шаардлага, үйл ажиллагааны хязгаарлалтын журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНК ҮҮСГЭН БАЙГУУЛАХ**

#### **15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах**

15.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах зөвшөөрлийг Монголбанк олгоно.

15.2.Гадаад улсын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах, эсхүл хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нийт гаргасан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас, эсхүл өр төлбөрийн эх үүсвэрийн хөрөнгийн 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг холбогдох хуульд заасны дагуу урьдчилан авсан байна.

15.3.Гадаад улсын хуулийн этгээд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн хуулийн этгээд нь зөвхөн банк, санхүүгийн байгууллага байх бөгөөд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь тухайн хуулийн этгээдийн охин компани байна.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасан хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагаа эрхлэх эх үүсвэр нь эдийн засгийн харьяат бус этгээдээс гарал үүсэлтэй гадаад валют байх буюу тухайн этгээдийн эзэмшиж байгаа Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр бүрдүүлээгүй байна.

15.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг бусдад худалдах, шилжүүлэхийг хориглоно.

15.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигч нь тус банкны нийт гаргасан хувьцааг дангаар эзэмшиж болно.

### **16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагчид тавих шаардлага**

16.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулагч нь Банкны тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, 23.1-д заасан шаардлагыг хангасан байна.

16.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь энэ хуулийн 16.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

16.2.1.гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байх;

16.2.2.хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг зөрчсөн тохиолдолд өөрийн хөрөнгийн шаардлагыг хангах хэмжээний хөрөнгийг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд оруулах үүрэг хүлээсэн байх;

16.2.3.үүсгэн байгуулагч улсын банк, санхүүгийн байгууллагын хяналт шалгалт, зохицуулалтад олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт мөрдөгддөг байх;

16.2.4.сүүлийн таван жилийн хугацаанд өөрийн улсын болон бусад улсын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөнөөс үүдэн банк, түүний нэгж байгуулах зөвшөөрөл нь хүчингүй болж, төлбөрийн чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүй;

16.2.5.үүсгэн байгуулагч хуулийн этгээд, түүний удирдлага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

16.2.6.Банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа нийцүүлэх чадвартай байх.

### **17 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулахад бүрдүүлэх баримт бичиг**

17.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч нь Банкны тухай хуулийн 20.1 болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн<sup>8</sup> 16.1-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

17.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах гадаад улсын банк, санхүүгийн байгууллага нь энэ хуулийн 17.1 болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

17.2.1.харьяалах улсын эрх бүхий зохицуулагч байгууллагаас Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэр;

17.2.2.хуульд заасан бол Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу авсан зөвшөөрөл.

17.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үүсгэн байгуулах болон өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргах, эзэмшихэд тавих нөхцөл, шаардлагыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран тогтооно.

<sup>8</sup>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

### **18 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох**

18.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, бусад баримт бичгийг Монголбанк хянахдаа дараах шаардлага хангасан эсэхийг тогтооно:

18.1.1.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлага;

18.1.2.Банкны тухай хуульд заасан банкны хяналт шалгалт, албадлагын арга хэмжээг аливаа саадгүй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой эсэх.

18.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Монголбанк хүлээн авахдаа энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлага, 17 дугаар зүйлд заасан баримт бичгийн бүрдлийг хянах бөгөөд хэрэв нэмэлт баримт бичиг шаардлагатай бол уг нэмэлт баримт бичгийг бүрдүүлж өгсөн өдрийг өргөдөл хүлээн авсан өдөрт тооцно.

### **19 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах**

19.1.Монголбанк дараах үндэслэлээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

19.1.1.энэ хуулийн 5, 16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

19.1.2.Банкны тухай хуулийн 24.1-д заасан үндэслэлээр.

### **20 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг бүртгэх**

20.1.Энэ хуульд заасны дагуу Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

20.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг улсын бүртгэлд бүртгэсэн тухай нийтэд мэдээлнэ.

### **21 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэр**

21.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэр нь түүний оноосон нэр болон “хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэсэн үгнээс бүрдэнэ.

21.2.Гадаад улсын банк, санхүүгийн байгууллагын үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэр нь толгой компанийн нэр болон “хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэсэн үгнээс бүрдэнэ.

21.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэрийг Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр хуулийн дагуу өөрчилнө.

## **22 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

22.1.Монголбанк хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, нийтэд зарлана:

22.1.1.хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг зарласан, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

22.1.2.энэ хуулийн 5, 16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон;

22.1.3.Банкны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ УДИРДЛАГА, ТАЙЛАН, ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

### **23 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны удирдлага**

23.1.Гадаад улсын банк, санхүүгийн байгууллагаас үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны толгой компанийн удирдлагыг хэрэгжүүлэгч эрх бүхий этгээдээс томилно.

23.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хоёроос доошгүй гишүүн, гүйцэтгэх удирдлага нь төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, банк, санхүүгийн байгууллагад таваас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай этгээд байна.

23.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлөөлөн удирдах зөвлөл таваас доошгүй гишүүнтэй байх ба хоёроос доошгүй хараат бус гишүүнтэй байна.

23.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрх бүхий албан тушаалтан нь тухайн банканд кастодиан, үнэлгээний болон аудитын үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд байхыг хориглоно.

#### **24 дүгээр зүйл.Санхүүгийн тайлан**

24.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн<sup>9</sup> дагуу санхүүгийн тайлан гаргана.

#### **25 дугаар зүйл.Хяналт шалгалт**

25.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, актив, пассив, өөрийн хөрөнгөд тавих шаардлага болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

25.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч гадаад улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран хяналт шалгалт хийж болно.

25.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагчийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага энэ хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

#### **26 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

26.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль<sup>10</sup>, Эрүүгийн хууль<sup>11</sup> болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

<sup>9</sup>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>10</sup>Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>11</sup>Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 05 дугаарт нийтлэгдсэн. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.













- ᠔᠖. Көштөн тэмдэг .. хүндийг Кэнширэг . асарууц дүр лухарисаг Рамчигдасо . Рамчигдасо болоуи
- ᠔᠗. ᠖.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр ᠒᠖ Көрөн тэмдэг Көү Көншсүр Рамчигдасо дүр Рөхмөррөг Көү Көншсүр болоуи . Рамчигдасо дүр Рөхмөррөг Көнширэг . асарууц Көү Көншсүр Көнширэг . асарууц Көү Көншсүр болоуи ..
- ᠔᠘. ᠗.᠐᠖ . асарууц дүр ᠒᠖ – Көү Көншсүр дүр Рамчигдасо Көнширэг . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠔᠙. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . Рөхмөррөг Рамчигдасо дүр Рөхмөррөг Рамчигдасо болоуи ..
- ᠕᠐. ᠙.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠑. ᠖.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠒. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠓. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠔. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠕. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠖. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠗. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠘. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠕᠙. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..
- ᠖᠐. ᠗.᠐᠖ . Рөхмөррэг Рамчигдасо асарууц дүр Рамчигдасо асарууц болоуи . асарууц Көү Көншсүр Рамчигдасо болоуи ..









᠖᠔. Кэнцэн дэмдэг .. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо

᠖᠕. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠖᠖. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠖᠗. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠖᠘. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠖᠙. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн  
гэдүйлхэнг амхэнсисо

᠗᠐. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠗᠑. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠗᠒. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:

᠗᠓. Речиссериа амхэмтэмгэр дэр хэмхэгдээрээр иэрэрд Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо  
Ухэнцисо хөгжсөн гэдүйлхэнг амхэнсисо:













## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Банкны тухай хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2<sup>1.2</sup> дахь хэсэг нэмсүгэй:

“2<sup>1.2</sup>.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах зөвшөөрөл олгох, үүсгэн байгуулах болон хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулиар зохицуулна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Бичигтэй хамт

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

“Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах зөвшөөрөл олгох, үүсгэн байгуулах болон хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулиар зохицуулна.”

Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Г.ЗАНДАНШАТАР



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “хөрөнгө оруулалтын сан” гэсний өмнө “хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мөрдөгч Галд\_02 Н011

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ  
ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ

ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ  
ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ  
ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ

ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ  
ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ  
ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ

ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ

ᠶ᠋ᠢᠨᠬᠡᠭᠦᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 дүгээр  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 7.2.7 дахь заалт нэмсүгэй:

“7.2.7.хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкинд байршуулсан хөрөнгө.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ  
ᠶ᠋ᠢᠨᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Автотээврийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

2/Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

3/Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

4/Байгаль орчныг хамгаалах тухай болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Байгалийн ургамлын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

6/Байгаль орчны багц хуулийн төсөл;

7/Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8/Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/Боловсролын ерөнхий хуулийн төсөл;

10/Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл;

11/Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл;

12/Газрын багц хуулийн төсөл;

13/Геодези, зураг зүйн тухай хуулийн төсөл;

14/Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл;

15/Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;





16/Дээд боловсролын тухай хуулийн төсөл;

17/Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл;

18/Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

20/Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Зөрчлийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

22/Казиногийн тухай хуулийн төсөл;

23/“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

24/Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл;

25/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

26/“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

27/Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

28/Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

29/Нас барсан өндөр насны тэтгэврийн зээл авагчийн



тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хуулийн төсөл;

30/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

31/Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл;

32/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөл;

33/Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөл;

34/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

35/“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл;

36/“Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл;

37/Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

38/Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөл;

39/Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

40/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

41/Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

42/Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

43/Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл

/Шинэчилсэн найруулга/;

44/Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөл  
/Шинэчилсэн найруулга/;

45/Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төсөл болон Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

46/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл;

47/“Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын  
хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төсөл;

48/Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төсөл;

49/Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд  
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

50/Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл;

51/“Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их  
Хурлын тогтоолын төсөл;

52/Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
орлуулах тухай хуулийн төсөл;

53/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл  
/Шинэчилсэн найруулга/;

54/Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн  
төсөл /Шинэчилсэн найруулга/;

55/Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төсөл;

56/Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл;

57/Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

58/Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг  
зохицуулах тухай хуулийн төсөл.

2.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч,  
Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их  
Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын  
Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2023  
оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд туссан хууль тогтоомжийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ

2023 оны 05 сарын 05 - өдөр  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06

Бусад хэсгээр харуулсан үйлчилгээний үнэ  
06 сарын 06













## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

### Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай

**Нэг.** Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт “Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 25.8.4. шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх” гэж тус тус заасны дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй гэж үзэв.

### Хоёр. Тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага

Эрүүгийн хэргийн танхимаас шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан саналыг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргах шаардлагатай болох нь дараах байдлаар тогтоогдсон гэж үзлээ.

2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас тайлбар гаргах шаардлагатай гэж үзсэн зүйл, хэсэг, заалтад санал авах тухай Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 02/3605 дугаартай албан бичгийн дагуу нийслэл болон орон нутгийн 28 шүүхээс гаргасан саналын үндэслэлийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн нэгтгэж, 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 1/668 дугаартай албан бичгээр Эрүүгийн хэргийн танхимд ирүүлсэн болно. Анхан болон давж заалдах шатны шүүхүүдээс гаргасан саналыг судалж үзэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т заасан шүүгчийг татгалзан гаргах үндэслэл, мөн зүйлийн 10.3 болон 10.4 дүгээр зүйлд заасан шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журмыг зохицуулсан зарим заалтыг нэг мөр

ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргуулах саналыг 5 шүүх ирүүлжээ.

2.2. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1638 дугаар албан бичгээр “Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд томилогдсон гурван шүүгчээс татгалзсан тохиолдолд уг асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэх эсэх” талаар,

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 1/2891 дугаартай албан бичгээр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүх бүрэлдэхүүний олонхыг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзсан бол уг асуудлыг шүүх хуралдаан даргалагч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ”, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “... нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан тохиолдолд энэ тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ” гэж тус тус заасан бөгөөд дээрх зүйлд заасан нийт шүүгч гэдгийг хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүний бүх шүүгч, эсхүл тухайн шүүхийн нийт шүүгч гэж үзэн шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэхэд ойлгомжгүй байдал үүсэж байх тул дээрх хуулийн зүйл, хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх” талаар,

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1003 дугаартай албан бичгээр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т “... энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл”, мөн хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “... нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргах ...” гэснийг, мөн хуулийн 10.4 дүгээр зүйлийн 4 болон 7 дахь хэсгийн заалттай уялдуулан татгалзагдсан шүүгч шүүгчдийн зөвлөгөөнд оролцож, санал өгөх эрхтэй эсэхийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргуулах хүсэлтийг тус тус Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимд ирүүлсэн байна.

2.3. Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим 2022 онд эрүүгийн хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон үндэслэлээр шүүхийн харьяаллыг өөрчлөн тогтоолгох талаар анхан болон давж заалдах шатны зарим шүүхээс ирүүлсэн 10 хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэжээ. Тухайлбал, хэргийн оролцогч нь шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс гадна томилогдоогүй шүүгчийг хамруулан тухайн шүүхийн нийт шүүгчээс хуульд заагаагүй үндэслэлээр

татгалзсан хүсэлтийг шүүгчдийн зөвлөгөөн хангаж шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцож болохгүй үндэслэл”, мөн хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан “... нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт”-ийг шийдвэрлэх журмыг буруу тайлбарлаж хэрэглэсэн нь шүүхийн харьяаллыг өөрчлөх хүсэлтийг хүлээж авахаас татгалзах үндэслэл болсон байна.

2.4. Эрүүгийн хэргийн танхимын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн нийт шүүгчийн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүгчийг татгалзан гаргах үндэслэл, түүнийг шийдвэрлэх журмын талаар шүүхүүдээс ирүүлсэн саналыг хэлэлцээд, холбогдох шүүхийн шийдвэр, практикийг судлах шаардлагатай гэж үзэж, судалгаа хийлгэхээр захиалга өгсний дагуу Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс холбогдох судалгааг хийж, 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр тайланг ирүүлжээ.

Судалгааны дүгнэлтээс үзэхэд шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан оролцогчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.4-т заасан “... энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл” гэх заалтын агуулгыг хэт өргөжүүлэн ойлгож, хэрэглэх хандлага түгээмэл байна.

Түүнчлэн хүсэлт гаргагчаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, дүрмүүдэд заасан тодорхой үндэслэлийг дурдахгүйгээр шүүгчээс татгалзах хүсэлт гаргасныг шүүх хүлээж авч шийдвэрлэх, энэхүү шийдвэртээ хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээний актуудад тодорхойлсон үндэслэлүүдийг баримтлахгүйгээр хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна.

Иймд шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах үндэслэл, шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэхэд шүүхийн практикт үүссэн ойлголтын зөрүү, хуулийн буруу хэрэглээг арилгах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар анхан болон давж заалдах шатны шүүхүүдээс ирүүлсэн санал, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн хийсэн судалгааны тайланг Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцээд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулахаар шийдвэрлэжээ.

2.5. Шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, бусад оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах, эсхүл хэргийн оролцогч хуульд заасан үндэслэлээр шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, бусад

оролцогчийг татгалзан гаргах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх журам болон хүсэлтийг шийдвэрлэсний дараах үр дагаврыг тус тус зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтуудын талаар шүүхүүдээс ирүүлсэн санал, судалгааны тайлан зэргээс үзэхэд, зарим нэр томъёоны ойлгомжгүй байдал, зүйл, заалт хоорондын уялдаа холбоо оновчтой биш, зохицуулалтын хийдэл, дутагдлын улмаас шүүхүүд “шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах (гаргах)”-тай холбоотой энэ хуулийн зарим зохицуулалтыг шүүхийн практикт зөрүүтэй хэрэглэсэн байдал тогтоогдлоо.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1.4-т заасан “...энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл” гэх зохицуулалтын шалгуурыг хэрхэн тогтоох, 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан “...нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргах...” гэсэн заалтад тухайн шүүх бүрэлдэхүүнд томилогдоогүй шүүгчийг хамааруулан ойлгох эсэх, мөн шүүх бүрэлдэхүүнд томилогдсон бүх шүүгчээс татгалзсан тохиолдолд уг асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэх эсэх, түүнчлэн татгалзагдсан шүүгч шүүгчдийн зөвлөгөөнд оролцож санал өгөх эрхтэй эсэх талаар шүүхийн практикт нэгдсэн ойлголт байхгүйгээс шүүхүүд дээрх хуулийн зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэгжүүлж байгаа нь холбогдох шүүхийн шийдвэрүүдээр тогтоогджээ.

2.6. Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргасан бөгөөд уг тайлбарыг гаргахад баримталсан зарчим, үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлд заасан ижил зохицуулалтыг тайлбарлахад жишиг болгон хэрэглэж, шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэхэд салбар эрх зүйн процессын хуулиудын нэгдмэл байдлыг хангах шаардлагатай гэж үзсэн болно.

## **Гурав. Тайлбарын цар хүрээ**

3.1. Тайлбарын цар хүрээ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн дараах хэсэг, заалтуудаар хязгаарлагдана.

3.1.1. 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасан “... хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол”;



3.1.2. 10.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “...Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй”;

3.1.3. 10.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах тухай хүсэлтийг прокурор, оролцогч гаргаж болно”;

3.1.4. 10.4 дүгээр зүйлд заасан “Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хянан шийдвэрлэх”;

3.1.5. 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан “... нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан”;

3.1.6. 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан “... тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ”.

### **Дөрөв. Тайлбарын арга зүй**

Тайлбарын холбогдох хэсэг тус бүрд тохирох хууль тайлбарлах аргаар, тухайлбал нэр томъёог үгийн шууд утга болон хэл зүйн дүрмээр; хуульд нэр томъёоны тодорхойлолт хийсэн бол тэр утгаар нь тайлбарлах (authentic); хууль зүйн ойлголт, ухагдахууныг эрх зүйн онол, нийтлэг зарчимд нийцүүлэн тайлбарлах; хэд хэдэн ойлголтын нийцлийг хангах, зөрчлийг шийдвэрлэх үүднээс логик болон системчлэлийн (хэм хэмжээний бүтцийн нэгдмэл, уялдаатай байдлыг хангах-structural), ойлголтуудыг цэгцлэн тайлбарлах (hermeneutic) болон хуулийн зорилго, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн тайлбарлах (teleological) аргаар тус тус тайлбарлана.

### **Тав. Тайлбарын дэлгэрэнгүй үндэслэл**

5.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим зохицуулалтыг хэрэглэхэд баримтлах нийтлэг зарчим, ерөнхий үндэслэлүүд:

5.1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч дараах үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй” гэж зааснаас үзвэл “татгалзан гарах”, “татгалзан гаргах” ойлголт нь тухайн хэргийг хянан шийдвэрлэхээр хуульд заасан үндэслэл журмын дагуу томилогдсон шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хамааралтай бөгөөд хууль тайлбарлах системчлэлийн аргаар авч үзвэл, хуулийн бусад зүйл, заалтуудад байгаа “шүүгчийг

татгалзах”-тай холбоотой агуулгад тухайн хэргийг хянан шийдвэрлэхээр томилогдоогүй шүүгч хамааралгүй, хамааралгүй шүүгчийг “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах” тухай хууль зүйн ойлголт үүсэхээргүй байна.

Иймд, “шүүгчийг татгалзан гаргах”, “шүүгч өөрөө татгалзан гарах” ойлголтыг зөвхөн тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдсон шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хамааруулан авч үзэхээр хуулийн зохицуулалтыг тайлбарлав.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу, хуулиар байгуулагдсан шүүхээс татгалзах ойлголт, боломжийг хуулиар тогтоогоогүй, хуульд заасан үндэслэлээр, хэргийг хэрэг хянан шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүний шүүгчийг нэрлэн зааж гаргаагүй буюу “шүүхээс татгалзах” агуулгатай хүсэлтийг хуульд нийцээгүй гэж үзэхээр тодруулав.

5.1.2. Хуульд заасан “шүүгчийг татгалзан гаргах”, “шүүгч өөрөө татгалзан гарах” ойлголтыг зөвхөн тухайн хэргийг хянан шийдвэрлэхээр томилогдсон шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хамааруулан авч үзэх зарчмын хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан “нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан” гэх зохицуулалтыг тодруулах шаардлага үүсэв.

Тухайн хэргийг хянан шийдвэрлэхээр томилогдоогүй шүүгчийг “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах” ойлголт үүсэхгүй тул хуулийн “нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан” гэдгийг тухайн нөхцөлд уг шүүхийн бүх шүүгч нь бүрэлдэхүүний шүүгч болж байгаа тохиолдлыг ойлгохоор тайлбарлалаа.

5.1.3. Шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, өөрөө татгалзан гарах нь тухайн шүүгчийн хувьд шүүн таслах чиг үүргээ тухайн хэргийн хувьд хэрэгжүүлэх боломжгүй болох үр дагавартай тул шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, өөрөө татгалзан гарах хуульд заасан үндэслэл нь объектив шалгууртай байхаар байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан аль ч нөхцөлийг шүүх шалгахдаа түүний объектив байдлыг харгалзан үзэх, тухайн нөхцөлд, хүсэлтэд дурдсан үндэслэл нь бодитой байх шаардлагыг хангах ёстой гэж үзэв.

5.1.4. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нь шүүгчийн нэн тэргүүний үүрэг болохын хувьд шүүгч нь хэрэг, маргааныг Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн хэнээс ч хараат бусаар бие даан шийдвэрлэхээ



илэрхийлж, тангараг өргөдөг ба шүүгч хуулиар хүлээсэн үүргээ хараат бусаар бие даан хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх бодитой хүчин зүйлсийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцож болохгүй үндэслэлүүд хэмээн хуульчилсан болно.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заагаагүй үндэслэлээр шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлт гаргасан, эсхүл шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гаргасан тохиолдолд ийм хүсэлтийг хэлэлцэхээс татгалзаж, шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах шүүн таслах ажиллагааны зарчимд нийцнэ гэж үзлээ.

5.1.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүгчийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх", мөн зүйлийн 7 дахь хэсэгт "Ерөнхий шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх шүүгчдийн зөвлөгөөнд Ерөнхий шүүгч уг асуудлын талаар тайлбар гаргаж болох боловч санал өгөх эрхгүй" гэж тус тус зааснаар хуульд заасан үндэслэлээр өөрийг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргахаар прокурор, оролцогчийн гаргасан хүсэлтийг татгалзагдсан шүүгч, эсхүл Ерөнхий шүүгч өөрөө оролцож шийдвэрлэхгүй байх зарчмыг нэгэнт хуульчилсан байх тул хуулийг тайлбарлах системчлэлийн болон логикийн арга зүйн үүднээс авч үзвэл, "шүүгчийг татгалзан гаргах тухай" асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байгаа бүх тохиолдолд уг шаардлага нь ижил тавигдах ёстой.

Иймд, шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гаргасан бүх тохиолдолд уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх ажиллагаанд тухайн шүүгч өөрөө оролцохгүй байх нийтлэг зарчмыг баримтлахаар тайлбарлалаа.

5.2. Хуулийг тайлбарлахад, дээр дурдсан ерөнхий үндэслэл, зарчмуудыг нийтлэг байдлаар баримтлахын зэрэгцээ зарим зохицуулалтын онцлог, тусгай байдалд нийцүүлэн дараах үндэслэл, зарчмуудыг баримтлан тайлбарлана.

5.2.1. Хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т заасан "... хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол" гэх заалтын хууль зүйн агуулгыг тодорхойлохдоо Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3-т заасантай агуулга, зорилгыг нь уялдуулан авч үзэв.

Шүүхийн шийдвэр, практикаас үзвэл “... хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол” гэх заалтын агуулгыг шүүхүүд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж, шүүгчийг татгалзах хүсэлтийг харилцан адилгүй шийдвэрлэж байна.

Тухайлбал, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасан “олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал”-ыг “... хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэлд хамааруулан ойлгож, нэг нутгийн, эсхүл нэг ангид хамт сурч байсан гэх шалгуураар шүүгчийг татгалзан гаргах, мөн дээрх үндэслэлээр шүүгч татгалзан гарах хүсэлт гаргасныг хангаж шийдвэрлэсэн тохиолдлууд гарсан байна.

Иймд, дээрх ойлголтын хууль зүйн агуулга, түүнд хамаарах “хувийн харилцаатай”, “хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байх”, “ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй” зэрэг нөхцөл байдлыг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын 1 болон 3 дахь хэсэгт зааснаар ойлгохоор тодорхойллоо.

5.2.2. Хуулийн 10.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн заалтын “Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч”, “уг хэргийг” гэх хууль зүйн ойлголтуудыг тайлбарлахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг болон тусгай ойлголт, зарчмуудад үндэслэж, үгийн шууд утгаар нь тайлбарлав.

Мөн зүйл, хэсэгт заасан “Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч ...” гэж тухайн хэргийг анхан, давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд дангаар болон шүүх бүрэлдэхүүнд багтаж, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг дүгнэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд оролцсон шүүгчийг ойлгох бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлд зааснаас бусад (хамтран ажиллах этгээдээр тогтоох) хуулиар харьяалуулсан асуудлыг хянан шийдвэрлэхэд оролцсон, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, оролцогчийн гаргасан хүсэлтийг хянан шийдвэрлэсэн шүүгч хамаарахгүй болохыг тайлбарлав.



Мөн зүйл, хэсэгт заасан “уг хэргийг” гэдэг нь тухайн яллагдагч (шүүгдэгч)-д холбогдуулан прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн агуулгаар тодорхойлогдоно гэж үзэв.

5.2.3. Хуулийн 10.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах тухай хүсэлтийг прокурор, оролцогч гаргаж болно” гэж заасантай уялдуулан энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, эсхүл шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гаргах нь шүүх хуралдааныг хойшлуулж, уг хүсэлтийг мөн хуулийн 10.4 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэх үндэслэл болохгүй тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан тохиолдолд “татгалзал гаргаагүйд тооцох”-оор тайлбарлав.

Татгалзал гаргаагүйд тооцох нь эцсийн шийдвэр бөгөөд уг шийдвэрийг гаргасан үндэслэлээр шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлт гаргаж болохгүй. Түүнчлэн, “шүүгч шийдвэр гаргах” агуулгын хүрээнд, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэлэлцүүлэгт үг хэлэх, илтгэл тавих, мөн шүүх хуралдааны явцад асуусан асуулт, харилцаа, хандлагын байдал зэрэг нь дангаараа тухайн шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хуульд заасан үндэслэлд хамаарахгүй гэж тодруулав.

5.2.4. Хуулийн 10.4 дүгээр зүйлд заасан “Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хянан шийдвэрлэх” журмын зарим заалтыг тайлбарлахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг болон тусгай ойлголт, зарчмуудад үндэслэж, системчлэх, логикийн болон хэл зүйн утгаар тайлбарлах аргуудыг ашиглалаа.

Татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх нийтлэг журмыг шүүгч өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах хүсэлт гаргасан тохиолдолд адил баримтална гэж үзэв.

5.2.5. Шүүхийн шийдвэр, практикаас үзэхэд тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд оролцоогүй, шүүх бүрэлдэхүүнд томилогдоогүй шүүгчийг хамааруулан, нэг хүсэлтээр тухайн шүүхийн бүх шүүгчээс, эсхүл тухайн шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэхээс татгалзах хүсэлт гаргасан тохиолдолд шүүх уг хүсэлтийг хүлээн авч, Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэсэн тохиолдол гарсан байх тул нийт шүүгчийг татгалзан гаргах ойлголтыг хуулийн холбогдох бусад зүйл, заалтуудтай уялдуулан тайлбарлах шаардлага үүссэн байна.

Иймд хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “... нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан” гэснийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын 9 дэх хэсэгт зааснаар ойлгохоор тодорхойллоо.

5.2.6. Шүүгчдийн зөвлөгөөнөөр тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүх бүрэлдэхүүн, эсхүл нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хэлэлцэхэд татгалзагдсан Ерөнхий шүүгч, бусад шүүгч ирц бүрдүүлж оролцох эсэх талаар хуульд нарийвчлан заагаагүй, энэ талаар шүүхүүд нэгдсэн ойлголтгүйгээс хуулийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж, зарим тохиолдолд татгалзагдсан шүүгч өөрийг нь татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд саналын эрхтэй оролцох явдал гарсан байна.

Иймд, шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гаргасан бүх тохиолдолд уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх ажиллагаанд шүүгч өөрөө оролцохгүй байх нийтлэг зарчмыг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд бусад үндэслэлээр Ерөнхий шүүгч, шүүх бүрэлдэхүүн, нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэхэд тухайн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний ирц бүрдэхгүй болсон тохиолдолд уг хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “... тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ” гэдгийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын 12 дахь хэсэгт зааснаар ойлгож хэрэглэхээр тайлбарлав.

Шүүгчдийн зөвлөгөөний ирц бүрдэхгүй болсон тохиолдолд татгалзан гаргах (гарах) хүсэлтийг адил шатны өөр шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнд шилжүүлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан (Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол тухайн хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл сум буюу сум дундын шүүхээс дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын шийдвэрээр, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, эсхүл өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрээр шүүхийн харьяалал тогтоон шилжүүлнэ) журмыг адилтгаж хэрэглэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтыг удирдлага болгон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим заалтыг

## ТАЙЛБАРЛАХ нь:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын: "... хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол" гэснийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын 1 болон 3 дахь хэсэгт зааснаар ойлгоно.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн:

“оролцсон шүүгч” гэж тухайн хэргийг анхан, давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд дангаар болон шүүх бүрэлдэхүүнд багтаж, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг дүгнэж шийдвэрлэхэд оролцсон шүүгчийг ойлгох бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлд зааснаас бусад (хамтран ажиллах этгээдээр тогтоох) хуулиар харьяалуулсан асуудлыг хянан шийдвэрлэхэд оролцсон, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, оролцогчийн гаргасан хүсэлтийг хянан шийдвэрлэсэн шүүгч хамаарахгүй.

Мөн зүйл хэсэгт заасан “уг хэргийг” гэдэг нь тухайн яллагдагч (шүүгдэгч)-д холбогдуулан прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн агуулгаар тодорхойлогдоно.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах тухай хүсэлтийг прокурор, оролцогч гаргаж болно” гэж заасантай уялдуулан уг хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, эсхүл шүүгч хуульд зааснаас бусад үндэслэлээр өөрөө татгалзан гарах хүсэлт гаргаж болохгүй.

Шүүгч шийдвэр гаргах агуулгын хүрээнд, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэлэлцүүлэгт үг хэлэх, илтгэл тавих, мөн шүүх хуралдааны явцад асуусан асуулт, харилцаа, хандлагын байдал зэрэг нь дангаараа тухайн шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хуульд заасан үндэслэлд хамаарахгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлт гаргасан тохиолдолд

шүүгч, шүүх бүрэлдэхүүн татгалзал гаргаагүйд тооцож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

Татгалзал гаргаагүйд тооцох нь эцсийн шийдвэр бөгөөд уг шийдвэрийг гаргасан үндэслэлээр шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлт гаргаж болохгүй.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлд заасан “Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хянан шийдвэрлэх” журмыг шүүгч өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах хүсэлт гаргасан тохиолдолд адилтган хэрэглэнэ.

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “... нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан” гэдгийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын 9 дэх хэсэгт зааснаар ойлгоно.

6. Хуульд заасан үндэслэлээр Ерөнхий шүүгч, шүүх бүрэлдэхүүн, нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэхэд Шүүгчдийн зөвлөгөөний ирц бүрдэхгүй болсон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “... тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ” гэдгийг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 36 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарын 12 дахь хэсэгт зааснаар ойлгоно.

Хүсэлтийг адил шатны өөр шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнд шилжүүлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмыг адилтгаж хэрэглэнэ.

Шүүгчдийн зөвлөгөөн татгалзан гаргах (гаргах) хүсэлтийг шийдвэрлэхдээ хүсэлтэд дурдсан үндэслэл, тайлбар, түүнд холбогдох баримтыг үндэслэнэ.

7. Энэ тогтоолыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**

**Д.ГАНЗОРИГ**

**ШҮҮГЧ**

**Б.БАТЦЭРЭН**



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

### **Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай**

**Нэг.** Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1-д “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 4/ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 -д “Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 25.8.4 шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх” гэж тус тус заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй гэж үзэв.

### **Хоёр. Тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага**

Иргэний хэргийн танхимаас шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан саналын дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргах шаардлагатай болох нь дараах байдлаар тогтоогдов.

2.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас тайлбар гаргах шаардлагатай гэж үзэж буй, тухайлбал шүүхүүд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж байгаа зохицуулалтын практик хэрэглээг судлах зорилгоор Иргэний хэргийн танхимын тэргүүний 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 3/3602 дугаар албан бичгийг Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүдэд хүргүүлж, 35 шүүхээс санал авсны дотор шүүгчийг татгалзан гаргах, шүүгч татгалзан гарах үндэслэл, хүсэлтийг шийдвэрлэх журмыг зохицуулсан хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргуулах саналыг 9 шүүх ирүүлжээ.

2.2. Тухайлбал, Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөний 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 135/ЗТ2022/00439 дүгээр тогтоолоор “...хэргийн оролцогчоос гаргасан аливаа хүсэлтийг шүүгч бүрэн эрхийн хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т заасны дагуу шийдвэрлэсэнтэй холбоотой татгалзах явдал түгээмэл байна. Энэ тохиолдолд шүүгчээс татгалзах хүсэлтийг хүлээн авч, хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр шүүх хуралдааныг хойшлуулах, эсхүл хүсэлтийг үндэслэлгүй гэж хуралдааныг үргэлжлүүлэх эсэх” талаар,

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 1/1995 дугаар албан бичгээр “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-т заасан “...шүүх хуралдаан эхлэхээс өмнө” болон “шүүх хуралдааны явцад тогтоогдвол” гэснийг шүүхүүд зөрүүтэй тайлбарлан хэрэглэдэг. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн ихэвчлэн хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасан шатанд татгалзах хүсэлт шийдвэрлэгдсэн гэх үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгодог нь хууль зөрчсөн эсэх” талаар,

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөний 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 183/ЗТ2022/01764 дүгээр тогтоолоор “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-т зааснаар ...шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэх үүрэгтэй гэдгийг хэрхэн зөв ойлгож хэрэглэх” талаар,

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 1136 дугаар албан бичгээр “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-т заасан ...эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэх үүрэгтэй гэснийг энэ талаар мэдэгдсэн бол татгалзлыг шийдвэрлэхээр шүүх хуралдааныг хойшлуулах, эсхүл тэмдэглэлд тусгаад хурлаа үргэлжлүүлэх аль нь эсэх” талаар,

Сүхбаатар аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхээс 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 1/57 дугаар албан бичгээр “Орон нутгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2-3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаатай холбоотойгоор хэргийг хянан шийдвэрлэх гэж байгаа нэг шүүгчээс бусад шүүгчдийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-д заасан үндэслэлээр татгалзаж, хэрэг



хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болсон үед татгалзлыг шийдвэрлэсэнтэй холбоотой шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд зааснаар гомдол гаргадаг. Гомдлыг шийдвэрлэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйн улмаас өөр аймаг дахь анхан шатны шүүх рүү гомдлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлэх шаардлага гардаг. Гэтэл тухайн шүүх гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэггүй. Учир нь гомдлыг шилжүүлэх зохицуулалт иргэний процессын хуульд байхгүй. Харин дээрх тохиолдолд зарим шүүхүүд хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хэргээ шийдвэрлүүлэхээр шилжүүлдэг боловч тухайн хэргийг хянан шийдвэрлэх нэг шүүгч байгаа тохиолдолд хэргийг шилжүүлэх боломжгүй, эдгээр асуудлыг хэрхэн зохицуулах” талаар,

Баянхонгор аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөний 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 131/ЗТ2022/00064 дүгээр тогтоолоор “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8-д Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана гэжээ. Гэтэл практикт орон нутгийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүд нь 2 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа тохиолдолд Ерөнхий шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг нөгөө шүүгч хүлээн авч шийдвэрлэхдээ шүүгчдийн зөвлөлгөөн хийх боломжгүй, бүрэлдэхүүн хүрэлцэхгүй, асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдал үүсэж байх тул энэ байдлыг хэрхэн ойлгох талаар тодорхой болгох” талаар,

Дорнод аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 3/560 дугаар албан бичгээр “...хуулийн 92 дугаар зүйлийн 92.6-д хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж захирамж гаргана гэж, 92.8-д Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана гэж зохицуулсан. Харин шүүх бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч орсон тохиолдолд талууд бүрэлдэхүүнээр нь татгалзаж байна. Энэ тохиолдолд татгалзлын асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй. Шүүхийн практикт хуулийн 92 дугаар зүйлийн 92.8-д заасныг баримтлан тус шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөр татгалзлыг шийдвэрлэж байгаа нь хуульд нийцэх эсэх” талаар тус тус албан ёсны тайлбар гаргуулах хүсэлтийг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимд ирүүлсэн байна.

2.3. Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүгчийг татгалзан гаргах үндэслэл, түүнийг шийдвэрлэх журмын талаар шүүхүүдээс ирүүлсэн саналыг хэлэлцээд, холбогдох шүүхийн шийдвэр, практикийг судлах шаардлагатай гэж үзэж, судалгааг Улсын дээд шүүхийн Практик судлалын хэлтэстэй хамтран хийв.

2.4. Мөн “Шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”-г Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээр хийлгэж, 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдах үеийн хуулийн төсөл хэлэлцсэн болон хууль баталсан хуралдааны тэмдэглэл, төслийн танилцуулга, үзэл баримтлалд тусгагдсан энэ тайлбарлаж буй хуулийн зүйл заалтад хамааралтай хэсгийг судлав.

2.5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92, 93 дугаар зүйлд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх журам болон хүсэлтийг шийдвэрлэсний үр дагаврыг тус тус зохицуулсан бөгөөд шүүхүүдээс ирүүлсэн санал, судалгааны тайлан зэргээс үзэхэд, тайлбарлаж буй зүйл, хэсэг, заалтын зарим нэр томъёоны ойлгомжгүй байдал, зүйл, хэсэг, заалт хоорондын уялдаа холбоо оновчтой биш, зохицуулалтын хийдэл, дутагдалтай, үүний улмаас шүүхүүд шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах, шүүгч өөрөө татгалзан гарахтай холбоотой энэ хуулийн зохицуулалтуудыг хэрэглэхдээ зөрүүтэй практик тогтоосон байдал түгээмэл байна.

Үүнд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасан гэр бүл, төрөл, садан гэх тусдаа бие даасан хууль зүйн ойлголтын хоорондын ялгааг гаргадаггүй, тухайн хэргийн оролцогч нь шүүгчтэй ямар байдлаар төрөл, эсхүл садан болж байгаа нь тодорхой бус, хуулийн 92 дугаар зүйлийн 92.6-д заасан шүүгчийг татгалзан гаргах үндэслэл байгаа эсэхийг хянан шийдвэрлэх Ерөнхий шүүгчийн ажиллагааг, 105 дугаар зүйлийн 105.1-д заасан шүүх хуралдааныг хэргийн оролцогчийн хүсэлтээр хойшлуулах, эсхүл шүүх хуралдааныг хуульд заасан дэгийн дагуу явуулах шүүгчийн ажиллагаанаас зааглаж, эдгээр хоёр субъектийн бүрэн эрхийн ялгамжтай байдлыг тодорхойлдоггүй, Ерөнхий шүүгч хэргийг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцож түүнийг татгалзсан, түүнчлэн тухайн шатны бүх шүүгчдийг татгалзсан бол татгалзлыг хэрхэн



шийдвэрлэх, татгалзлыг шүүгчдийн зөвлөлгөөнөөр хэлэлцэх тохиолдолд татгалзан гаргагдаж буй Ерөнхий шүүгч, шүүгч өөрөө оролцох эсэх, санал гаргах эсэх нь тодорхойгүй, татгалзан гарах хүсэлт шийдвэрлэх шүүгчдийн зөвлөлгөөний ирц хүрэлцэхгүй үед татгалзлыг хэрхэн шийдвэрлэх нь ойлгомжгүйгээс шүүхүүд хуулийн зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэжээ.

### **Гурав. Тайлбарын цар хүрээ**

3.1. Тайлбарын цар хүрээ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлүүдийн дараах хэсэг, заалтуудаар хязгаарлагдана.

3.1.1. 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан “анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх”; “уг хэрэг, маргаан”;

3.1.2. 91 дүгээр зүйлийн 91.1.2-т заасан “гэр бүл”; “төрөл”; “садан”;

3.1.3. 91 дүгээр зүйлийн 91.2-т заасан “шүүгчийг татгалзаж үл болно”;

3.1.4. 92 дугар зүйлийн 92.5-д заасан “бусад шүүгч шийдвэрлэнэ”;

3.1.5. 92 дугаар зүйлийн 92.6-д заасан “хэд хэдэн шүүгч”;

3.1.6. 92 дугаар зүйлийн 92.8-д заасан “шүүгчдийн зөвлөлгөөн”; “бүх шүүгчдийг татгалзсан”;

### **Дөрөв. Тайлбарын арга зүй**

Тайлбарын холбогдох хэсэг бүрийг тухайн хэсэгт тохирох аргаар, тухайлбал нэр томъёог үгийн шууд утга болон хэл зүйн дүрмээр; суурь болон нарийвчилсан бусад хуулиар тогтоосон нэр томъёоны тодорхойлолтын агуулгаар; эрх зүйн онол, нийтлэг зарчимд нийцүүлэн өргөжүүлэн, эсхүл нарийвчлан тайлбарлах аргаар; хэм хэмжээний нийцлийг хангах, зөрчлийг шийдвэрлэх үүднээс логик болон системчлэлийн аргыг хэрэглэж, ойлголтуудыг цэгцлэх; хуулийн зорилго, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн тайлбарлах аргуудыг тохируулан хэрэглэв.

## **Тав. Тайлбарын үндэслэл**

Эрх зүйн ерөнхий онолын хувьд шүүгч өөрөө татгалзан гарах, шүүгчээс татгалзах зохицуулалтын зорилго нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хадгалах, хангах, аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байдлаас сэргийлэх явдал байдаг.

Нөгөө талаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн хамгаалалт юм.

Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг зохицуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн холбогдох хэм хэмжээг тайлбарлахдаа дараах нийтлэг болон тусгай зарчмын хүрээнд нэг мөр ойлгож, хэрэглэх үндэслэлийг анхаарч үзсэн болно. Үүнд:

### **5.1. Шүүгчийг татгалзан гаргах, шүүгч өөрөө татгалзан гарах ойлголтын талаар**

Энэ ойлголт нь хууль зүйн хувьд зөвхөн тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд оролцож буй шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хамаарна. Уг зарчим нь “тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзах” гэх ойлголтод мөн хамаарч, шүүгч бүр хэргийг хянан шийдвэрлэхээр томилогдсон, түүнийг татгалзан гаргах хүсэлт гаргасан хуулийн урьдчилсан нөхцөл тогтоогдох үндэслэлийг тайлбарлав.

“Шүүхийг татгалзах”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзах” хууль зүйн ойлголт байхгүй бөгөөд хуульд заагаагүй үндэслэлээр татгалзах боломжгүй тул хүсэлт гаргаагүйд тооцох ойлголтыг хууль хэрэглээнд нэг мөр болгоно.

### **5.2. Шүүгчийг татгалзан гаргах, шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэлийн талаар**

5.2.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91 дүгээр зүйлд шүүгчийг татгалзан гаргах, шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэлийг зохицуулсан.

Эдгээр үндэслэлүүдийг ангилж үзвэл:

1. Гэр бүл, төрөл, садан, хувийн харилцаа /ИХШХШТХ 91.1.2, 91.1.3/

2. Ашиг сонирхлын зөрчил /ИХШХШТХ 91.1.4/

3. Шүүгч хэргийг шударгаар шийдвэрлэж эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ үүсэх /ИХШХШТХ 91.1.3/

4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үндэслэл /ИХШХШТХ 91.1.1, 84 дүгээр зүйл/ гэсэн төрөлд хуваагдаж байх ба үүнээс өөр үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно гэж хуульчилснаас үзэхэд шүүгчийг татгалзах үндэслэл нь императив хэм хэмжээний шинжтэй байна.

Түүнчлэн татгалзах үндэслэлийг тоочиж, жагсаалт хэлбэрээр хуульд тусгасан бөгөөд үүнээс хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1, 91 дүгээр зүйлийн 91.1.2-т заасан зарим зохицуулалтыг нарийвчилсан бусад хуулиар тогтоосон нэр томъёоны агуулга болон эрх зүйн онол, нийтлэг зарчимд нийцүүлэн өргөжүүлэн тайлбарлав.

5.2.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.2-т зааснаар шүүгч “уг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн гэр бүл, төрөл, садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүн хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон байвал татгалзах үүрэгтэй” бөгөөд энэ тохиолдолд нотолгоо шаардахгүй. Уг зохицуулалтын “**гэр бүл**”, “**төрөл**”, “**садан**” гэх ойлголтуудыг тусад нь тайлбарлаж, үүнтэй холбоотой Улсын Дээд шүүхийн 2002 оны 263 дугаар тайлбарын 23 дахь хэсгийг хүчингүй болгоно. Гэр бүл гэх нэр томъёог Гэр бүлийн тухай хуульд тайлбарласан байдаг боловч шүүгчийн татгалзлын хүрээнд хамт амьдарч байгаагаас гадна тусдаа амьдарч буй гэрлэгчид, тэдгээрийн хүүхдүүдийг хамааруулж өөрөөр тайлбарлах үндэслэл, шаардлага байгаа, мөн төрлийг 4 үеэр хязгаарлах нь зүйтэй гэж үзсэн.

5.2.3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан “Иргэний хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхэд урьд нь оролцсон шүүгч уг хэрэг, маргааныг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн зохицуулалтын “**анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх**” гэдэгт энэ хуулийн 115 дугаар зүйлийн 115.1, 167 дугаар зүйлийн 167.1, 176 дугаар зүйлийн 176.2-т тус тус зааснаар шийдвэр, магадлал, тогтоолыг гаргасан гэж ойлгохыг тайлбарласнаар шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, хэргийг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг буцаасан, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан зэрэг шийдвэр гаргасан шүүгч хамаарахгүй хуулийн үндэслэлийг тодорхой болгосон болно.

Харин хуульд анхан шатны шүүхийн шийдвэр гаргасан шүүгч буюу шүүх бүрэлдэхүүний хувьд шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэх аль ч шатны хуралдаанд оролцохгүй гэдгийг тодорхой, эргэлзээгүй заажээ.

Мөн “уг хэрэг, маргаан” гэдгийг тухайн иргэний хэрэг гэж ойлгох ба хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан тохиолдолд уг хэрэгтэй өөр хэргийг нэгтгэсэн, эсхүл тухайн хэргийн хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагыг тусгаарласнаар тусдаа хэрэг үүсгэсэн бол тэдгээр хэргүүд мөн адил хамаарахыг тайлбарлав.

### 5.3. Шүүгчийг татгалзаж үл болох үндэслэлийн талаар

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т зааснаар энэ хуулийн 84 дүгээр зүйл, 91.1-д зааснаас бусад үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос шүүгч өөрөө татгалзах, эсхүл шүүгчийг татгалзан гаргахыг хориглоно гэж ойлгохыг тайлбарлав.

Тухайлбал, тухайн хэргийг дангаар болон бүрэлдэхүүнээр шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй шүүгчийг татгалзсан, ижил үндэслэлээр татгалзах хүсэлтийг дахин гаргасан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэнтэй холбогдуулан татгалзсан нь хуульд заагаагүй үндэслэлд хамаарна.

Хуулийн 106 дугаар зүйлийн 106.1-д заасны дагуу хэрэг хэлэлцэж эхэлснээс хойш дээрх үндэслэлээр гаргасан хүсэлтийг гаргаагүйд тооцож хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн үзвэл энэ талаар тэмдэглэлд тусгаж шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж болно.

Энэхүү нөхцөл нь хуулийн 92 дугаар зүйлийн 92.5, 92.6, 92.8-д заасан шүүгчийг татгалзан гаргах үндэслэл байгаа эсэхийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний бусад шүүгч, Ерөнхий шүүгч, шүүгчдийн зөвлөлгөөний ажиллагааг, хуулийн 105 дугаар зүйлд заасан шүүх хуралдааныг хэргийн оролцогчийн хүсэлтээр хойшлуулах, эсхүл шүүх хуралдааныг хуульд заасан дэгийн дагуу явуулах шүүгч, шүүх бүрэлдэхүүний ажиллагаанаас зааглаж, эдгээр субъектүүдийн бүрэн эрхийн ялгамжтай байдлыг тодорхойлно гэж үзвэл.

#### **5.4.Татгалзан гаргах асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.5-д “Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг үндэслэлтэй эсэхийг түүнийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчид шийдвэрлэнэ. Санал тэнцвэл шүүгчийг татгалзан гаргасанд тооцно” гэж, мөн хуулийн 92 дугаар зүйлийн 92.6-д “Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж захирамж гаргана” гэж татгалзан гаргах асуудлыг хянан шийдвэрлэх журмыг заасан.

Хуулийн эдгээр зохицуулалтын “бусад шүүгч шийдвэрлэнэ” гэснийг болон “хэд хэдэн шүүгч”-ийг хэрхэн ойлгохыг тайлбарласнаар Ерөнхий шүүгч болон татгалзагдаагүй шүүх бүрэлдэхүүний зүгээс “татгалзан гаргах асуудлыг” хэрхэн шийдвэрлэх ялгаа заагийг тодорхой болгосон.

#### **5.5.Татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэх шүүгчдийн зөвлөлгөөний эрх хэмжээний талаар**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8-д “Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.” гэсэн заалтыг бүхэлд нь эрх зүйн онол нийтлэг зарчимд нийцүүлэн өргөжүүлэн тайлбарласан.

“шүүгчдийн зөвлөлгөөн” гэдэг нь тухайн шүүхийн болон адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөн гэсэн агуулгатай болохыг, шүүгчдийн зөвлөлгөөнөөр шийдвэрлэгдэх татгалзлын асуудал, хүрээ хязгаар, адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөр шийдвэрлүүлэх үндэслэлийг тайлбарлаж, татгалзан гаргагдаж байгаа шүүгчийн эрх, татгалзлыг хэрхэн шийдвэрлэх журмыг тайлбарлаж нэг мөр ойлгож хэрэглэх нөхцөлийг хангасан болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.5-д шүүх бүрэлдэхүүний цөөнхийг татгалзах, 92.6-д шүүх бүрэлдэхүүний олонхийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзах, 92.8-д тухайн шатны бүх шүүгчдийг татгалзах тохиолдлыг ялгамжтай хуульчилж, шийдвэрлэх үр дагаврыг өөр өөрөөр зохицуулсан боловч шүүхийн практикт гарч буй зарим асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь ойлгомжгүйн улмаас эдгээр хэм хэмжээг тус бүрээр тайлбарласан нь хууль хэрэглээнд ач холбогдолтой гэж үзлээ.

Адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөр татгалзан гаргах асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлэхдээ тогтоолд хүсэлт, холбогдох баримтыг хавсаргаж хүргүүлэх, тухайн шүүхийг түргэн шуурхай, зардал багатай шийдвэрлэх байдлыг нь харгалзан сонгохыг, түүнчлэн тогтоолын үндэслэл болон харьяаллын талаар шүүхүүд хоорондоо маргаж болохгүйг тус тус тайлбарлав.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтыг удирдлага болгон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг

**ТАЙЛБАРЛАХ нь:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсгийн:

**“анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх”** гэдгийг энэ хуулийн 115 дугаар зүйлийн 115.1, 167 дугаар зүйлийн 167.1, 176 дугаар зүйлийн 176.2-т зааснаар шийдвэр, магадлал, тогтоол гаргасан байхыг ойлгоно.

**“уг хэрэг, маргаан”** гэдэгт тухайн иргэний хэрэг гэж ойлгох бөгөөд хэргийг дахин шийдвэрлэх явцад нэгтгэсэн болон тусгаарласан бол тэдгээр хэргүүд мөн адил хамаарна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.2 дахь заалтын:

**“гэр бүл”** гэдэгт гэрлэгчид, тэдгээрийн хамт, эсхүл тусдаа амьдарч буй төрсөн, дагавар болон үрчлэн авсан хүүхэд хамаарна.

**“төрөл”** гэдэгт гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг ойлгоно.

**“садан”** гэдэгт гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг ойлгоно.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсгийн:

**“шүүгчийг татгалзаж үл болно”** гэсэн зохицуулалтыг энэ хуульд

заагаагүй үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос шүүгч өөрөө татгалзах, эсхүл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс шүүгчийг татгалзан гаргахыг хориглоно гэж ойлгоно.

Тухайн хэргийг дангаар болон бүрэлдэхүүнээр шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй шүүгчийг татгалзсан, ижил үндэслэлээр татгалзах хүсэлтийг дахин гаргасан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэнтэй холбогдуулан татгалзсан нь хуульд заагаагүй үндэслэлд хамаарна.

Энэ хуулийн 106 дугаар зүйлийн 106.1-д заасны дагуу хэрэг хэлэлцэж эхэлснээс хойш дээрх үндэслэлээр гаргасан хүсэлтийг гаргаагүйд тооцож хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн үзвэл энэ талаар тэмдэглэлд тусгаж шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсгийн:

**“бусад шүүгч шийдвэрлэнэ”** гэдгийг анхан болон давж заалдах шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний нэг шүүгчийг, хяналтын шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр хүртэл шүүгчийг татгалзсан бол уг хүсэлтийг бүрэлдэхүүний үлдэх шүүгчид хэлэлцэж тогтоол гаргахыг ойлгоно.

Хуулийн энэ хэсэгт заасан шүүгчийг, шүүгчид гэдэгт Ерөнхий шүүгч нэгэн адил хамаарна.

5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.6 дахь хэсгийн:

**“хэд хэдэн шүүгч”** гэж хэргийг хянан шийдвэрлэхээр томилогдсон шүүх бүрэлдэхүүний олонхийг ойлгоно.

Хуулийн энэ хэсэг нь татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэх Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг зохицуулсан тул шүүх бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч оролцоогүй тохиолдол гэж үзнэ.

6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8 дахь хэсгийн:

**“шүүгчдийн зөвлөлгөөн”** гэдгийг тухайн шүүхийн болон адил



шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөн гэж ойлгоно.

Ерөнхий шүүгч оролцсон шүүх бүрэлдэхүүнийг бүхэлд нь, эсхүл бүрэлдэхүүний олонхийг татгалзсан, түүнчлэн Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан тохиолдолд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөр шийдвэрлэнэ.

Харин тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан, эсхүл нийт шүүгчийн олонхийг татгалзсанаас шүүгчдийн зөвлөлгөөний ирц бүрдэхгүй болсон тохиолдолд хүсэлтийг адил шатны өөр шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөн хэлэлцэж шийдвэрлэнэ.

Татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэхэд татгалзан гаргагдаж байгаа шүүгч оролцохгүй. Энэ нь татгалзлын талаар тайлбар гаргах шүүгчийн эрхийг хязгаарлахгүй.

**“бүх шүүгчдийг татгалзсан”** гэдгийг иргэний хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд тухайн шүүхийн бүх шүүгч оролцсон бөгөөд тэдгээрийг татгалзсаныг ойлгоно.

Хүсэлтийг шийдвэрлэх адил шатны өөр шүүхийг түргэн шуурхай, зардал багатай шийдвэрлэх байдлыг нь харгалзан сонгож, шүүгчдийн зөвлөлгөөний тогтоолыг хүсэлт, холбогдох баримтын хамт хүргүүлнэ.

Адил шатны өөр шүүх татгалзан гаргах хүсэлтийг даруй шийдвэрлэж, шүүгчдийн зөвлөлгөөний тогтоолоо баримтуудын хамт холбогдох шүүхэд буцаан хүргүүлсний дараа үр дагаврыг энэ хуулийн 93 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

Тогтоолын үндэслэл болон харьяаллын талаар шүүхүүд хоорондоо маргаж болохгүй.

7. Тайлбар гаргасантай холбогдуулж Улсын дээд шүүхийн 2002 оны 263 дугаар тогтоолын 23 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

8. Энэ тогтоолыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**

**Д.ГАНЗОРИГ**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Г.АЛТАНЧИМЭГ**





**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 4

**Индекс: 200003**